



Далын ахлагч
Жайро Мазагарди

ЭЭЖЭЭСЭЭ СУРСАН ЗҮЙЛ



Бага байхад мөнгөтэй болох бүрд
Ээж минь хамгийн бага үрчий-
сэн, цэвэрхэн дэвсгэртүүдийг аваад,
бидний явдаг байсан сүмийн сан-
ваартанд өгдөг байсан юм. Тэрээр
үүнийг бүх амьдралынхаа турш
хийсэн. Тэр “Энэ бол Бурханы өмч”
гэж хэлдэг байлаа. Тэр үг миний
сэтгэлд хоногшиж үлдсэн юм.
Ээж минь аравны нэгийн хуулийг
дуулгавартай дагахыг надад заа-
сан учраас насанд хүрсэн хойноо
Есүс Христийн Хожмын Үеийн
Гэгээнтнүүдийн Сүмд баптисм хүр-
тэж, аравны нэгээ төлөх нь надад
хэцүү байсангүй.

Түүнчлэн ээж минь надад
хэцүү зүйлийг хийх байсан ч
үнэнч шударга байхыг заасан.
Манай хөрш олон төрлийн
жимс, ногоо тарьдаг байсан юм.
Заримдаа жимс нь манай хашаа
руу түрж орон ургадаг байлаа. Нэг
удаа намайг хэдэн жимс түүгээд,
ээждээ аваачиж өгөхөд тэр над
руу хараад, “Энэ биднийх биш
шүү дээ” гэв. Би ингэж хэлсэнд нь
итгэж чадахгүй байлаа. Би “Юу



гэсэн үг вэ? Манай хашаан дотор
байна шүү дээ!” гэв. Тэр “Энэ бид-
нийх биш ээ” гэж дахин хэллээ.
Тэгээд тэр намайг гараас минь
хөтлөөд, хөршийн гэр рүү явж
билээ. Бид түүний жимсийг авсан-
даа уучлал гуйв. Ээж маань хэрэв
бид ямар нэг зүйл авахыг хүсвэл
шударгаар олж авах ёстой гэж
хэлдэг байсан.

Та нарын эцэг, эх Сүмийн
гишүүн биш эсвэл та нар тэдний

ЭЦЭГ, ЭХЭЭСЭЭ АСУУ

Эцэг, эх байхын юу нь танд хамгийн
их таалагддаг вэ?

Хамгийн хэцүү нь юу вэ?

Таныг юу аз жаргалтай болгодог вэ?

Таны өдөр бүр хийдэг хамгийн чухал
зүйл юу вэ?

Сайн мэдээ танд сайн эцэг, эх байхад
хэрхэн тусалдаг вэ?

Таны өдөр бүр хамгийн сүүлд хийдэг
зүйл юу вэ?

Та нар өөр ямар асуулт тавьж болох вэ?

Нэг өдрийн турш ээж, аавынхаа
туслагч нь байгаарай! Сурсан зүйлээ
өдрийн тэмдэглэлдээ бичиж эсвэл
зураарай. Эцэг, эхдээ хийдэг бүх
зүйлийнх нь төлөө талархаарай.

сонголттой заримдаа санал нийл-
дэггүй байж болно. Тэгсэн хэдий
ч та нар үнэнч шударга байдал,
үүрэг хариуцлага, бие даах чад-
вар, шаргуу хөдөлмөрлөх зэрэг
үнэн зарчмуудыг тэднээс сурал-
цах боломжтой. Эдгээр зарчим
та нарын амьдралд агуу адислал
байх болно. ■